



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/424

Арвайхээр


**Хөрөнгө зарцуулах тухай**

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.10 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын "Ойгоос хушны самар бэлтгэж ашиглахыг бүсчлэн тогтоох тухай" 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/577 дугаар тушаал, Сангийн сайдын "Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 301 дүгээр тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12/02 дугаар тогтоолоор батлагдсан "Өвөрхангай аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн 1.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Аймгийн ой бүхий нутаг дэвсгэрээс хушны самар бэлтгэж ашиглахтай холбогдуулан хяналт шалгалт явуулах ажлын удирдамжийг нэгдүгээр, холбогдох зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хяналт шалгалт явуулахад шаардагдах зардал 2,701,800 (хоёр сая долоон зуун нэг мянга найман зуу) төгрөгийг аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100941